

САЙХАН СУМЫН 2017 ОНЫ 03 ДУГААР САРЫН ЭХНИЙ ХАГАСТ ЗОХИОН БАЙГУУСАН ДОТООД АЖЛЫН МЭДЭЭ

2017.03.14

Их Хүрэмт

Сайхан сумын Ундрах багийн малчин Мягмарсүрэнгийн Баасандамба, Авирмэдийн Лхагвасүрэн нар Улсын аварга малчинаар тодорч цагаан сарын баярын өмнө шагналаа гардан авлаа. Энэ жил манай сумаас нэг багаас, 2 улсын аварга малчин тодорсон нь бахархуштай сайхан зүйл боллоо.



1:10 бууз сайн үйлсийн аяны хүрээнд бүх байгууллагууд бууз цуглуулан амьжиргааны түвшин доогуур айл өрхүүдэд гардуулан өглөө.

3 сарын 08-ны Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 8 ээжийг төгс ээж, дархан бэрээр тодруулан шилдэг ээжээр өргөмжилж хүндэтгэл үзүүллээ. Сумын ЗДТГазар, Эмэгтэйчүүдийн зөвлөл хамтран зохион байгууллаа.

- Аюушийн Бурмаа Буян төгс ээж,
- Тогтохын Балжид Хичээнгүй төгс ээж,
- Жийжээ Мягмар Энэрэлт төгс,
- Должин Наранцэцэг Уран төгс ээж,
- Шаравын Цэцэгмаа Ачлалт төгс,
- Жамьянжавын Должинсүрэн Бишрэлт төгс ээж,
- Авирмэдийн Оюумаа Авьяас төгс ээж,

- Дагвын Лхагва Сайхан буурал ээж,
- Дагважамцын Отгонтuya Дархан бэр боллоо.



ЗДТГазар